

UCS.....B2023

ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ГАДНА ОРЧИН



Автомашин угаалгын газарт тавигдах ерөнхий шаардлага

ГАРЧИГ

1. ХАМРАХ ХҮРЭЭ	4
2. НОРМАТИВ ЭШЛЭЛ	4
3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ	4
4. АВТО МАШИН УГААЛГЫН ГАЗАРТ ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА.....	5
5. АВТОМАШИН УГААЛГЫН ГАЗРЫН ТӨРӨЛ, АНГИЛАЛ	5
6. АВТО МАШИН УГААЛГЫН ГАЗРЫН ГАДНА ОРЧИНД ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	7
7. АВТО МАШИН УГААЛГЫН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА	11
8. АВТО МАШИН УГААЛГА ЭРХЛЭГЧИЙН АЖИЛЛАХ БОЛОВСОН ХҮЧИНД ТАВИХ ШААРДЛАГА.....	12
9. АВТОМАШИН УГААЛГЫН ТЕХНОЛОГИ.....	12
10. БОХИР УСЫГ ЦЭВЭРШҮҮЛЭН ДАХИН АШИГЛАХ ТЕХНОЛОГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ШААРДЛАГА.....	13
11. ТУСГАЙ ШААРДЛАГА	14
12. ШАЛГАХ ХУУДАС.....	15
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	16

Зургийн жагсаалт

Зураг 1. Автомашиныг гар аргаар угаах үйл ажиллагаа (Жишээ зураг).....	6
Зураг 2. Автомашиныг хагас механикжсан аргаар угаах үйл ажиллагаа (Жишээ зураг).....	7
Зураг 3. Автомашиныг механикжсан аргаар угаах үйл ажиллагаа (Жишээ зураг)	7
Зураг 4. Автомашин угаалгын газрын гадна гэрэлтүүлэг (Жишээ зураг)	8
Зураг 5. Автомашин угаалгын газрын гадна камер (Жишээ зураг).....	9
Зураг 6. Утаат тамхи татах цэг (Жишээ зураг).....	9
Зураг 7. Автомашин угаалгын газрын гадна хаяг, байгууллагын нэрийн бичвэр (Жишээ зураг)	10
Зураг 8. Хог түр хадгалах цэг (Жишээ зураг).....	11
Зураг 9. Автомашин угаалгын газар (Жишээ зураг)	11
Зураг 10. Механикжсан аргаар автомашиныг угаах угаалгын газрын бохир усыг буцааж ашиглах технологи (Жишээ зураг)	14

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Түр зогсох талбайд тээврийн хэрэгслийн эзлэх талбайн хэмжээ, эргэлтийн радиус.....	7
Хүснэгт 2. Автомашины угаалга эрхлэгчдийн технологийн тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл.....	12
Хүснэгт 3. Шалгуур үзүүлэлт	15

ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ГАДНА ОРЧИН

АВТОМАШИН УГААЛГЫН ГАЗАРТ ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандарт нь авто угаалгын үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын барилга байгууламж, түүний гадна орчинд тавигдах шаардлагыг тогтоож, иргэн, аж ахуйн нэгж байгууллага хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтан дагаж мөрдөнө.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандартад эш татсан дараах барилгын норм ба дүрэм, стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- БНБД 31-03-03 Олон нийт, иргэний барилгын норм ба дүрэм;
- БНБД 32-01-06 Хот суурины гудамж, зам төлөвлөлтийн норм ба дүрэм;
- БНБД 30.01.04 Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм;
- БНБД 3.01.06-09 Барилгын орчны тохижилтын ажил;
- MNS 5347:2003 Автомашины угаалгын үйлчилгээ. Ангилал, Ерөнхий шаардлага;
- MNS 5025:2020 Авто үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага;
- MNS 5342 Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага;
- MNS 5021 Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ, ерөнхий шаардлага;
- MNS 5011 Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх заавар. Ерөнхий шаардлага;
- MNS 4596 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм;
- MNS 4597 Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 4759 Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 5537 Автозамын дагуух үйлчилгээний цогцолбор. Ангилал, ерөнхий шаардлага;
- UCS 0902B:2022 Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавигдах ерөнхий шаардлага
- UCS 1201B:2022 Худалдаа үйлчилгээний газрын гадна орчны ерөнхий шаардлага
- UCS 1703A:2022 Аюултай хог хаягдлын менежмент.
- UCS 1701A:2022 Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент.

3. НЭР ТОМЬЁНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Автомашины угаалга- гэж автомашины өнгө үзэмж, ариун цэврийг сайжруулах, эдэлгээг уртасгах, техникийн үйлчилгээ засварын ажил хийхийн өмнө болон сүүлд, зорчигчдод тав тухтай үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн угаах, хатаах өнгөлөх үйл ажиллагаа;

Угаалгын технологи- гэж автомашин угаах, хатаах, өнгөлөх ажилбаруудыг шаардлага хангасан барилга байгууламжид зориулалтын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар тодорхой цаг хугацаанд зохих нөхцөл шаардлагын дагуу мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэх ажлын дараалал;

Технологийн карт- гэж угаах, хатаах, өнгөлөх ажилбаруудын дэс дараалал, ажиллах боловсон хүчин, угаалгын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, зохих нөхцөл шаардлага ажил гүйцэтгэх хугацаа зэргийг тусгасан техникийн баримт бичиг;

Угаагч- гэж автомашин угаах технологи ажиллагааг зохих шаардлагын дагуу хийж гүйцэтгэх мэргэшсэн ажилчин;

Угаалгын байр- гэж автомашины угаалга хийх нөхцөл шаардлага хангасан технологийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл бүхий ажиллах орчин;

Саарал ус- ямар нэг ялгадасгүй зөвхөн ахуйн бохир усыг;

Хаягдал ус-гэж ахуйн хэрэглээ болон үйлдвэрлэл, үйлчилгээнээс гарч байгаа бохир ус, шингэн хаягдал;

Хаягдал усны стандарт- гэж усны бохирдлын эх үүсвэрээс гарч байгаа хаягдал усанд байж болох бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг эрх бүхий байгууллагаар баталгаажуулсныг;

4. АВТОМАШИН УГААЛГЫН ГАЗАРТ ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 4.1. Автомашины угаалга эрхлэгч иргэн, хуулийн этгээд нь холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу нутаг дэвсгэрийнхээ авто тээврийн ажил үйлчилгээг зохицуулдаг эрх бүхий мэргэжлийн болон бүртгэх байгууллагад бүртгүүлж дүгнэлт гаргуулсан байхаас гадна угаалгын барилга байгууламжийг эзэмших, ашиглахтай холбогдсон баримт бичгийг зохих ёсоор бүрдүүлсэн байна.
- 4.2. Автомашин угаах ажил үйлчилгээ нь хүрээлэн байгаа орчин, оршин суугчдад сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй галын болон аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, хөдөлмөрийн эрүүл ахуйн болон тав тухтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- 4.3. Автомашин угаалгын газарт яаралтай тусламжийн хэрэгсэл болон галын буланг байрлуулсан байна.
- 4.4. Ажил үйлчилгээтэй холбогдсон угаалгын технологийн карт, техникийн болон эрүүл ахуйн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын заавар, журмыг мөрдөнө.
- 4.5. Автомашиныг угаахад зориулалтын угаагч шингэн нунтгийг хэрэглэнэ.
- 4.6. Автомашины угаалга эрхлэгч нь технологийн картад заасан ажилбаруудыг зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэнэ.
- 4.7. Автомашины угаалгын үйл ажиллагаа эрхлэгч нь үйлчилгээнээс гарч байгаа цардсан, бохир усыг тунгааж, цэвэрлэх, цэвэршүүлсэн /саарал/ усыг тунгааж, дахин ашиглах тусгай төхөөрөмжөөр тоноглогдон үйл ажиллагааг эрхлэн явуулна.
- 4.8. Автомашин угаасан бохир усыг хөрсөнд шингэхгүй, нэвчилт явагдахгүй, гадна орчинд ашигласан бохир ус алдагдахгүй нөхцөлийг хангах.
- 4.9. Аюултай ачаа тээвэрлэдэг автомашиныг угаасан бохир усыг зөвшөөрөгдсөн газарт зохих шаардлагын дагуу асгана.
- 4.10. Автомашин угаалгын үйлчилгээг үзүүлэх тогтоосон батлагдсан үнийн талаарх мэдээллийг хэрэглэгчдэд урьдчилсан мэдээлэл өгөх байдлаар ил тод байршуулсан байна.
- 4.11. Гарал үүслийн гэрчилгээгүй, үйлдвэрлэгчээс тогтоосон баталгаат болон хадгалах хугацаа дууссан, чанарын шаардлага хангаагүй угаагч бодис хэрэглэхийг хориглоно.
- 4.12. Автомашин угаалгын газрын байршлын төлөв байдал, чанарын үнэлгээг хийлгэхдээ хөрсний бохирдлын судалгааг хийлгэж, чанар стандарт MNS 5850:2019-т харьцуулсан дүн мэдээг 5 жил тутам холбогдох түвшний байгууллагуудад мэдэгдэх.
- 4.13. Шинээр байгуулах болон одоо ажиллаж байгаа авто угаалгын газар нь байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг гаргуулж мөрдөн ажиллах.

5. АВТОМАШИН УГААЛГЫН ГАЗРЫН ТӨРӨЛ, АНГИЛАЛ


Автомашин угаахад ашиглаж байгаа тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн ажиллагаанаас хамааруулан гар аргаар, хагас механикжсан аргаар, механикжсан аргаар угаах гэж гурав ангилна. Автомашины угаалга нь авто тээврийн хэрэгслийн төрлөөс хамааран ачааны, суудлын, автобусны гэх мэт төрөлжсөн, эсвэл хосолсон гэж ангилах бөгөөд орц гарцын хувьд нэвт шугаман эсвэл нэг орц гарцтай байж болно.

- 5.1. **Автомашиньг гар аргаар угаах**- Зориулалтын нөхцөл шаардлага хангасан угаалгын байранд автомашины гадна талыг цахилгаан насостой шүршигч хошуугаар $2-4\text{кг}/\text{см}^2$ – аас багагүй даралттай усаар шүршиж, дотор талын хог, тоос шороог тоос сорогчоор соруулж, гар аргаар угаах ба хатаалтад шахсан хий болон зөөлөн хөвсгөр хуурай алчуурыг хэрэглэж, зориулалтын өнгөлгөөний нунтаг ашиглан гарааг өнгөлгөө хийх үйл ажиллагаа.




Зураг 1. Автомашиньг гар аргаар угаах үйл ажиллагаа (Жишээ зураг)

- 5.2. **Автомашиньг хагас механикжсан аргаар угаах**- Зориулалтын нөхцөл шаардлага хангасан угаалгын байранд автомашины гадна талыг эргэлдэгч сойз бүхий механикжсан шугамаар оруулж, дотор талын хог тоос шороог тоос сорогчоор соруулж, гар аргаар угаах ба хатаалтыг тусгай талбайд зогсоож шахсан хий болон зөөлөн хөвсгөр хуурай алчуураар арчиж, зориулалтын өнгөлгөөний нунтаг ашиглан гараар өнгөлгөө хийх үйл ажиллагаа.



Зураг 2. Автомашиныг хагас механикжсан аргаар угаах үйл ажиллагаа (Жишээ зураг)

5.3. **Автомашиныг механикжсан аргаар угаах**- Зориулалтын нөхцөл шаардлага хангасан угаалгын байранд автомашины гадна талыг эргэлдэгч сойз бүхий механикжсан шугамаар оруулж угаах ба хатаалтын мөн шугаманд халуун хийгээр үлээж хатаагаад, дотор талын хог тоос шороог тоос сорогчоор соруулж гар аргаар угаах ба зориулалтын өнгөлгөөний нунтаг ашиглан гараар өнгөлгөө хийх үйл ажиллагаа.



Зураг 3. Автомашиныг механикжсан аргаар угаах үйл ажиллагаа (Жишээ зураг)

6. АВТО МАШИН УГААЛГЫН ГАЗРЫН ГАДНА ОРЧИНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

6.1. Гадна зогсоолд тавигдах шаардлага

- Авто угаалгын газрын гадна зогсоол талбай нь UCS 0902B:2022 Тээврийн хэрэгслийн ил зогсоол төлөвлөх, байгуулахад тавигдах ерөнхий шаардлага хотын стандарт, Хот суурины гудамж зам талбайн төлөвлөлт БНБД 32-01-06 норм дүрэм, стандарт шаардлагын дагуу автомашин тавьж байршуулахад зориулсан хатуу хучилт бүхий тэгш талбайтай байна;
- Автомашин угаалгын үйлчилгээ эрхлэх барилга байгууламжийн гадна орчин нь “Худалдаа, үйлчилгээний газрын гадна орчны ерөнхий шаардлага UCS 1201B:2022” стандартын шаардлагыг хангасан байна.
- Авто тээврийн хэрэгсэл байрлуулах зогсоолын байрлалыг цагаан зураасаар, аюулгүйн тэмдэглэгээг шар зураасаар стандартын дагуу тэмдэглэж, зориулалтын зогсоолоос бусад газарт тээврийн хэрэгсэл байрлуулахыг хориглоно;
- Авто зогсоол нь борооны ус зайлуулах байгууламжтай байх ба хучилтын гадаргуугийн усыг далд байгууламжаар шийдэж Хот, тосгоны нутаг дэвсгэр, зам талбайгаас бороо, цасны усыг зайлуулах ажлын зурагт төсөл, тооцооны норм /БД 40-302-13/-г баримтлан төлөвлөнө.
- Түр зогсох талбайд байрлах тэ эврийн хэрэгслийн эзлэх талбайн хэмжээ, эргэлтийн радиусыг 1-р хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 1. Түр зогсох талбайд тээврийн хэрэгслийн эзлэх талбайн хэмжээ, эргэлийн радиус

Тээврийн хэрэгслийн төрөл	Эргэлтийн талбайн хэмжээ, м	Эргэлтийн радиус, м
Суудлын автомашин	2.5 x 5.4	6.3
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний автомашин	4.8 x 5.4	6.3

Ачааны автомашин		
Бага багтаамжтай	3.5 x 6.4	7.1
Дунд	3.5 x 6.8	9.0
Их	3.5 x 12.5	12

Эх сурвалж: "Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Автозамын дагуух үйлчилгээний байгууламж, үндсэн шаардлага" MNS 5537

6.2. Гэрэлтүүлэг, хяналтын камерын систем

- Гадна гэрэлтүүлэг нь авто засварын газрын гадна талбайг бүхэлд нь гэрэлтүүлэх боломжтой байх бөгөөд "UCS 1901В:2022 Гэрэлтүүлэх төхөөрөмжийг төлөвлөх, байрлуулах, суурилуулах удирдамж", "UCS 1901В:2022 Гэрэлтүүлэгт тавигдах шаардлага" хотын стандартуудын шаардлагыг хангасан байна;



Зураг 4. Автомашин угаалгын газрын гадна гэрэлтүүлэг (Жишээ зураг)


- Үйлчлүүлэгчид болон ажилчдын аюулгүй байдлыг хамгаалах, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гадна, дотор талыг хянах камер суурилуулсан, галын аюулгүй дохиоллоор тоногдсон байна;
- Хяналтын камер нь "Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага" MNS 6423:2019 стандартын шаардлагыг хангасан байна.



Зураг 5. Автомашин угаалгын газрын гадна камер (Жишээ зураг)

6.3. Утаат тамхи татах цэг

- Утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэг байгуулах үйл ажиллагаанд “Тамхины хяналтын тухай хууль”-ийг мөрдлөг болгоно;
- Утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийг явган хүний зам дээр байгуулахыг хориглох бөгөөд тухайн байгууламжийн төрлөөс хамааруулан явган хүний замаас хамгийн багадаа 5-10 метрийн зайд байрлуулна;
- Утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийн тамхи хаях хогийн сав нь зориулалт бүхий тасалгаатай, цэвэрлэх, халдваргүйжүүлэх боломжтой байна.



Зураг 6. Утаат тамхи татах цэг (Жишээ зураг)

6.4. Байгууллагын гадна хаяг, нэрийн бичвэрт тавигдах шаардлага

- Авто засвар үйлчилгээний байгууллагын нэр байршлын мэдээллийн самбарыг “UCS 1403B:2022 Гадна мэдээллийн байгууламжид тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартын шаардлагад нийцүүлэн байрлуулна;
- Самбарын бичвэр нь харагдахуйц, гаргацтай, өөрөөсөө буюу гаднаас гэрэлтүүлэгтэй, аудио болон дүрст видео төхөөрөмжөөр тоноглогдсон байж болно;
- Авто угаалгын газрын нэр, ажиллах цагийн хуваарь, бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээллийг агуулсан байна;
- Шаардлагатай тохиолдолд байгууллагын нэрийн бичвэрийг англи хэлээр бичиж болох бөгөөд англи хэл дээрх бичвэр нь монгол бичвэрийн доод талд байрлаж, түүнээс 2 дахин бага өндөртэй байх, эсхүл Монгол /кирилл/ бичвэрийн зүүн гар талд байрлаж, түүнтэй ижил өндөртэй байна;
- Байгууллагын нэрийн бичвэр нь утга төгөлдөр, ойлгогдохуйц, өнгө дизайн сайтай, хотын үзэмжид нийцсэн, орчин үеийн технологийн шийдлийг ашигласан байх бөгөөд ашиглагч байгууллагын зүгээс арчилгаа засвар, үйлчилгээг хийж, өнгө үзэмж бүрэн бүтэн байдлыг тогтмол хангуулна.



Зураг 7. Автомашин угаалгын газрын гадна хаяг, байгууллагын нэрийн бичвэр (Жишээ зураг)

6.5. Хог хаягдал түр хадгалах цэгт тавигдах шаардлага

- Автомашин угаалгын газар нь хог хаягдлыг түр хадгалах цэгийг байгуулахдаа “ UCS 1701A:2022 Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн удирдамж” хотын стандартын баримт бичгийг мөрдлөг болгоно.
- Хог хаягдлыг түр хадгалах эх үүсвэр дээр нь ангилан ялгасан байна.
- Хог хаягдал түр хадгалах цэг рүү орж хог ачих зориулалт бүхий орц гарцтай байхаар төлөвлөнө.
- Хог хаягдал түр хадгалах савнууд нь цаасан дахивар болон бусад хог хаях зориулалтыг заасан олон улсад хэрэглэгддэг мэдээлэх тэмдэгтэй байх ба хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн байх шаардлагатай.



Зураг 8. Хог түр хадгалах цэг (Жишээ зураг)

7. АВТО МАШИН УГААЛГЫН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 7.1. Авто машин угаалгын барилга байгууламж нь барилгын зураг төсөл, норматив техникийн баримт бичиг, холбогдох стандартын шаардлагыг бүрэн хангасан байна.
- 7.2. Автомашин угаалгын барилга, байгууламж нь агааржуулах, гэрэлтүүлэх, дулаацуулах систем галын аюулгүйн багаж хэрэгслээр бүрэн хангагдсан, тэдгээр нь хэвийн ажиллагаатай байна.
- 7.3. Автомашин угаалгын газар нь үйлчлүүлэгчид зориулсан эрүүл ахуйн шаардлага хангасан хүлээлгийн болон ариун цэврийн өрөөтэй байна.
- 7.4. Ариун цэврийн өрөө нь UCS 1401В:2022 Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавигдах шаардлага хотын стандартын шаардлагыг хангасан байна.
- 7.5. Ажилчдын хувцас солих болон амрах байр, бие засах газартай байна.
- 7.6. Суурин угаалгын газрын цэвэрлэх байгууламж нь угаалгын газраас 6 метрээс доошгүй зайд байрлана.



Зураг 9. Автомашин угаалгын газар (Жишээ зураг)

8. АВТО МАШИН УГААЛГА ЭРХЛЭГЧИЙН АЖИЛЛАХ БОЛОВСОН ХҮЧИНД ТАВИХ ШААРДЛАГА

- 8.1. Автомашины угаалга эрхлэгч байгууллагын дарга, менежерийн аль нэг нь мэргэшүүлэх сургалтад хамрагдаж үнэмлэх гэрчилгээ авсан байна.
- 8.2. Автомашины угаалгын газрын ажилтан нь технологийн тоног төхөөрөмж, багажтай ажиллахдаа хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан заавар зөвлөмжтэй заавал танилцсан байна.
- 8.3. Ажлын байранд хөдөлмөр хамгаалал, аюулгүйн техникийн шаардлага хангасан ажлын хувцсыг өмсөж хэрэглэнэ.
- 8.4. Автомашин угаалгын газарт ажилтан ажиллуулахдаа ажил олгогч, ажилтан хооронд хөдөлмөрийн гэрээг заавал байгуулсан байх ба насанд хүрээгүй хүүдээр хөдөлмөр эрхлүүлэхийг хориглоно.
- 8.5. Угаагч нь ус нэвтэрдэггүй малгай, бээлий, гутал, ажлын хувцсаар/аюултай ачаа тээвэрлэдэг автомашиныг угаагч нь тусгай зориулалтын хамгаалах хувцас хэрэгслээр/ бүрэн хангагдсан байна.

9. АВТОМАШИН УГААЛГЫН ТЕХНОЛОГИ

- 9.1. Автомашин угаах зориулалттай ажлын байрны температур +5 °С-ээс дээш байна.
- 9.2. Автомашиныг гар аргаар угаахдаа угаалгын байранд оруулж түүнийг өнхрөхөөс урьдчилан сэргийлж дугуйнд ивүүр хийж, дотор талын хог тоосыг соруулж цэвэрлээд, бүхээгт ус нэвтрэн орохоос хамгаалж хаалга, хаалганы шилийг сайтар хаагаад гадна талыг цэвэр усаар шүршихэд бэлтгэнэ.
- 9.3. Автомашины гадна талыг 0°С –аас +20°С хүртэл температуртай цэвэр даралттай усаар шүршсэний дараа 1 литр 7-8 грамм зориулалтын угаалгын нунтаг, эсвэл 4-5гр угаалгын шингэн ноогдож байхаар усыг найруулж нарийн угаалгын гар аргаар хийж дахин даралттай цэвэр усаар шүршиж угаасны дараа даралттай хийгээр үлээлгэх буюу хөвсгөр зөөлөн хуурай эсвэл чийгтэй алчуураар арчиж хатаана.
- 9.4. Автомашины гадна талыг угаасны дараа дотор талын угаалгыг гар аргаар угаахдаа дээрх орцоор угаах усыг хувинд найруулж хэрэглэнэ. Мөн цэвэр усаар угаагаад хөвсгөр зөөлөн хуурай эсвэл чийгтэй алчуураар арчиж хатаана
- 9.5. Автомашины угаах хугацаа нь автомашины төрөл, угаах аргаас хамааран гар болон хагас механикжсан аргаар угаахад 10-20 минут, механикжсан аргаар угаахад 3-6 минут байна.
- 9.6. Угаасан автомашины дотор, гадна талын өнгөлөг байдлыг хадгалах, толбо гүнзгий биш зурааснуудыг арилгахын тулд тусгай зориулалтын бодисуудыг ашиглан өнгөлгөөг гар аргаар хийнэ.
- 9.7. Автомашины угаалга эрхлэгчийн технологийн тоног төхөөрөмж, багажид тавих шаардлагыг 2-р хүснэгтэд харуулав.

Хүснэгт 2. Автомашины угаалга эрхлэгчийн технологийн тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл


№	Тоног төхөөрөмж багаж хэрэгслийн нэр	Зориулалт	Техникийн шаардлага
Суурин			
1	Суудлын автомашин угаах тоног төхөөрөмж	Угаалгын байранд суудлын автомашины кузов, явах ангийг угаана.	Арга-Автомат төхөөрөмжийн бүтээл 30-40 авт/цаг
2	Ачааны автомашин угаах тоног төхөөрөмж	Угаалгын байранд ачааны автомашины хажуу гадаргууг механик аргаар угаана.	Арга-Механик дамжуулгаар Төхөөрөмжийн бүтээл 20-30 авто/цаг

3	Автобус угаах тоног төхөөрөмж	Фургон маягийн кузовтой автомашин, автобусны гадна талыг угаана.	Арга-Автомат Төхөөрөмжийн бүтээл 30-35 авто/цаг Угаалгын үед автобусны шилжилтийн хурд 6-9 м/мин Усны даралт 3-4 кг/см ²
4	Автомашин угаах цахилгаан насостой шүршигч хошуу	Угаалгын байранд болон урсгал шугаман дээр автомашиныг шүршигч хошуугаар шүршиж угаана.	Арга-Гараар Усны даралт 1.5-3.5 кг/см ²
Зөврийн			
1	Угаалгын тоног төхөөрөмж	Автомашины гадна угаалгыг хийнэ.	Арга-Тохируулгатай шүршигч хоолойгоор
2	Шахсан хийгээр үлээх хошуу	Шахсан хийгээр автомашины кузовыг үлээж хатаана.	Арга-Гараар Ажлын даралт 4-10 кг/см ²

Эх сурвалж: "Автомашин угаалгын үйлчилгээ. Ангилал, Ерөнхий шаардлага" MNS 5347:2003

10. БОХИР УСЫГ ЦЭВЭРШҮҮЛЭН ДАХИН АШИГЛАХ ТЕХНОЛОГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ШААРДЛАГА

- 10.1. Автомашин угаалгын газар нь бохир ус эргэж шүүж, тунгааж ашиглах тусгай төхөөрөмжөөр тоноглогсон байна.
- 10.2. Автомашин угаалгын газар нь саарал ус ашиглах технологи, түүнд ашиглах төхөөрөмжийг угаалгын газрын төлөвлөлт байршил, барилгын хэлбэр хэмжээ техникийн нөхцөлтэй уялдуулан сонгоно.
- 10.3. Сараал усны системийг ашиглахдаа дараах хууль, стандартуудыг баримтална. Үүнд:
 - Усны тухай хууль;
 - Хот суурины ус хангам, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль;
 - Эрүүл ахуйн тухай хууль;
 - Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль;
 - Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хууль;
 - Ус бохирдуулсны тухай хууль;
 - MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, хаягдал ус ерөнхий шаардлага ;
 - MNS 6561:2015 Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усны ерөнхий шаардлага;
 - MNS 6734:2018 Дахин ашиглах цэвэрлэсэн усны техникийн шаардлага ;
 - MNS 12255:2015 Бохир ус цэвэрлэх байгууламж ;
 - MNS 5347:2003 Автомашины угаалгын үйлчилгээ;
 - MNS BS8525:2015 Саарал усны систем. Ерөнхий шаардлага ;
 - Хөрсний чанар. "харсанд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5850:2019" стандарт, хөрсөнд агуулагдах түгээмэл тархацтай бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй байх;



Зураг 10. Механикжсан аргаар автомашиныг угаах угаалгын газрын бохир усыг буцааж ашиглах технологи (Жишээ зураг)

11. ТУСГАЙ ШААРДЛАГА

- 11.1. Хүрээлэн буй орчин түүний хөрс, ус ногоон бүсийг хамгаалах, бохирдуулахгүй байх, нөхөн сэргээх, ногоон байгууламжийг бий болгох. Иргэн аж ахуйн нэгжийн автомашин угаалгын газар байгуулах эзэмшил бүхий газрын 20 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх /өөрийн эзэмшил талбайд тохижуулах боломжгүй бол нийтийн эзэмшлийн талбайд агаар орчны бохирдлоос сэргийлэх арга хэмжээг авч заавал хэрэгжүүлэх.
- 11.2. Хог хаягдал, бохирыг хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр “Бохир ус. Лагийн чийглэг ба үнслэгийг тодорхойлох арга” MNS 5667:2006 болон “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага” MNS 4943:2015 үндэсний стандартуудын дагуу төлөвлөх.
- 11.3. Ус цэвэршүүлж дахин ашиглах тоног төхөөрөмжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх
- 11.4. Автомашин угаалгын газарт хүн болон экологид хор нөлөө багатай угаалгын шингэнийг хэрэглэнэ.
- 11.5. Автомашин угаах зорилгоор гүний худаг гаргаж, гүний цэвэр ус ашиглахыг хориглоно.
- 11.6. Химийн найрлагатай угаалгын бодис ашигласан усыг шууд хөрсөнд асгахыг хориглоно.
- 11.7. Химийн найрлагатай угаалгын бодис ашигласан ус хөрсөнд асгарч, алдагдсан тохиолдолд яаралтай авах арга хэмжээ авах төлөвлөгөөтэй байна.

12. ШАЛГАХ ХУУДАС

Автомашин угаалгын газарт тавигдах ерөнхий шаардлагыг хангаж байгаа эсэхийг Хүснэгт 3-ийн дагуу хянан шалгаж, хүлээн авна.

Хүснэгт 3. Шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Автомашин угаалгын үйлчилгээ явуулж буй барилга байгууламж нь баримт бичгийн норматив эшлэлд тусгагдсан стандарт, норм дүрмийн шаардлагуудыг хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Автомашин угаалгын газрын гадна зогсоол талбай, түүний хучилт стандартын дагуу төлөвлөгдсөн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Гадна зам талбайд байршуулсан гэрэлтүүлэг нь стандартын шаардлага хангасан эсэх.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Барилгын гадна, дотно орчинд хяналтын камер байршуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Замын хөдөлгөөнд саад учруулхааргүй аюулгүй байдлыг хангасан орц гарц бүхий төлөвлөлтэй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Яаралтай түргэн тусламжийн болон гал унтраах хэрэгсэл бүхий галын булантай эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгөд нэрийн болон хаягийн бичвэрийг “UCS 1403B:2022 Гадна мэдээллийн байгууламжид тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартын шаардлагад нийцүүлэн байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Автомашин угаалгын газар нь бохир усаа эргүүлэн шүүж, тунгааж ашиглах тусгай төхөөрөмжөөр тоноглогдсон эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
9	Ус эргүүлэн дахин ашиглах тусгай төхөөрөмжид саатал гарсан тохиолдолд бохир усыг гадагш алдахгүй байх нөөц төлөвлөгөөтэй эсэх.	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
10	Автомашин угаалгын барилга, байгууламжийн агааржуулах, гэрэлтүүлэх, дулаацуулах систем галын аюулгүйн багаж хэрэгслээр бүрэн хангагдсан, тэдгээр нь хэвийн ажиллагаатай эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
11	Автомашин угаалгын газрын барилга нь төвийн цэвэр бохирын шугамд холбогдсон эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Автомашин угаалгын газар нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын үндсэн хууль
2. Хог хаягдлын тухай хууль;
3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль;
4. Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм;
5. Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага /Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17 өдрийн А/443 дугаар тушаал/;
6. Гадна зар сурталчилгаанд тавих шаардлага /Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 9/10 дугаар тогтоол/;
7. БНБД 31-03-03 Олон нийт, иргэний барилгын норм ба дүрэм;
8. БНБД 32-01-06 Хот суурины гудамж, зам төлөвлөлтийн норм ба дүрэм;
9. БНБД 30.01.04 Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм;
10. БНБД 3.01.06-09 Барилгын орчны тохижилтын ажил;
11. MNS 5025:2020 Авто үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага;
12. MNS 5342 Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага;
13. MNS 5021 Худалдааны газар, түүний үйлчилгээ, ерөнхий шаардлага;
14. MNS 5011 Авто тээврийн хэрэгслийн техникийн байдлын үзлэг хийх заавар, ерөнхий шаардлага;
15. MNS 5347 Автомашины угаалгын үйлчилгээ. Ангилал Ерөнхий шаардлага;
16. MNS 4596 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм;
17. MNS 4597 Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага;
18. MNS 4759 Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага;
19. MNS 5537 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Автозамын дагуух үйлчилгээний байгууламж, үндсэн шаардлага;
20. UCS 0902B:2022 Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавигдах ерөнхий шаардлага;
21. UCS 1201B:2022 Худалдаа үйлчилгээний газрын гадна орчны ерөнхий шаардлага;
22. UCS 1703A:2022 Аюултай хог хаягдлын менежмент;
23. Simoniz- Carwash building and equipment maintenance training
24. Capital regional district-Environmental Regulations and Best Management Practices Vehicle Wash Operations in the Capital Region

